



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 06/15

Улаан-Уул

Эмэгтэйчүүдээс гаргасан уриалгыг  
дэмжих тухай


Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр сумын эмэгтэйчүүдээс нийт ард иргэдэд хандан өрх бүр үйлдвэрлэгч болох, иргэн бүр мод тарих хөдөлгөөнд нэгдэх, эрүүл мэндээ хамгаалан үзлэг шинжилгээнд тогтмол хамрагдах, архи хорт зуршлаас татгалзах, цахим орчны хэрэглээг багасгах уриалгыг дэвшүүлснийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь эмэгтэй төлөөлөгчдөөс сайшаан дэмжиж байгааг ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.1, 63 дугаар зүйлийн 63.2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, 22 дугаар зүйлийн 22.1.2, 35 дугаар зүйлийн 35.1.11, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 6 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь;

1. Өрх бүр үйлдвэрлэгч байх, иргэн бүр мод тарих хөдөлгөөнд нэгдэх, эрүүл мэндээ хамгаалан үзлэг шинжилгээнд тогтмол хамрагдах, архи хорт зуршлаас татгалзах, цахим орчны хэрэглээг багасгах уриалгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг сумын Засаг дарга (Т.Эрдэнэбат), иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь эмэгтэй төлөөлөгчдөд тус тус даалгасугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Д.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ГОНГОР

Ёсчилсон 2022 оны 03 сарын 10 ны өдөр